

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 8 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, сумд болон Засаг даргын харьяа хэлтэс, агентлагийн дарга нарт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн сүлжээний хуудсанд 27 удаагийн фото, видео болон бичвэр бүхий мэдээ, мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны нийгмийн сүлжээ болон цахим хуудсаар иргэд, олон нийтэд түгээсэн цацсан бөгөөд давхардсан тоогоор нийт 154500 удаа үзсэн байна.

Япон улсын Засгийн газрын “ЖАЙКА” Олон улсын байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч, хувийн хэвшлийн салбар хариуцсан мэргэжилтэн Коизүми Тайга, хөтөлбөрийн ажилтан Ц.Хоролсүрэн нар 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдөр орон нутагт айлчилж, аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Байгаль, орчин, аялал, жуулчлалын газрын дарга, нартай уулзаж, аймаг, орон нутгийн хэмжээнд байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүн, цаашдын хөгжлийн төлөвлөлтийн талаар харилцан санал солилцлоо.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

8 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 3217566.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс 3327045.0 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

Улсын төвлөрсөн төсөвт 587490.0 мян төгрөг төвлөрүүлэхээс 587500.0 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

2020 оны 08 дугаар сарын 26-ний өдрийн байдлаар татвар төлөгч ХК-1, ХХК-304, ББН-5, ЗБН-10, хоршоо-27 ОНӨҮГ-6, салбар-70, хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, ТББ-93, шашны байгууллага-5, Сан-10, ОНБ-16 бүртгэгдэн нийт хуулийн этгээд 605 болж, 4.5 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 5669141.2 мянган төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 6023921.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 508468.4 мянган төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн чиглэлээр: 7 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулж, хэвлэмэл байдлаар 135, цахимаар 450 иргэнд хүргэсэн.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж шалгалтаар нийт 2321.6 мян төгрөгийн зөрчил илрүүлж 537.6 мян төгрөгийг холбогдох хүнээр нөхөн төлүүлж орон нутгийн орлого болгуулахаар нөхөн төлбөрийн акт тогтоосон. Шивээговь сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтаар нийт 15857.3 мян төгрөгийн зөрчил илрүүлсэнээс 1641.3 мян төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр, 1231.8 мян төгрөгийг хувь хүмүүст буцаан олгуулахаар нөхөн төлбөрийн акт тогтоож, 12984.2 мян төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгосон :Тэтгэвэр

№	Төрөл	2019.08.24		2020.08.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	
1	Өндөр настан	1703	4421646.1	1802	6222673.0	99

2	Тахир дутуу	331	648609.1	341	982248.4	10
3	Тэжээгчээ алдсан	113	234762.6	128	322527.0	15
4	Үйлдвэрийн осол	51	206838.3	27	111132.4	24
	Нийт дүн	2198	5511856.1	2298	7638580.8	148

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2019.08.24		2020.08.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	1034	123855.7	821	114645.3
2	ЖБА тэтгэмж	251	372605.2	274	471898.6
3	Оршуулга	41	42606.0	46	46000.0
4	ҮОМШӨ-ХЧТА	10	4226.3	2	4521.5
5	Ажилгүйдэл	132	239064.7	511	318455.9
	Нийт дүн	1468	782357.9	1654	955521.3

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2019.08.24	2020.08.24
Шинээр	172	292
Мөнгө тушаасан	661	410
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	138652.1	109147.5

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын ажлын чиглэлээр: Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1997-2018 оны 15 хөмрөгийн 95 хадгаламжийн нэгжийн 3353 хуудас баримтын 1712 заалт, 13084 хүний нэр, 2480 байгууллагын нэр, 6163 газар зүйн нэр, 3696 хуудас баримт программд холбож, 1672 хуудас баримт фотошоп программаар янзалж, 2593 хуудас баримт скайнердсан. Архивын баримтаас 16 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 2
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 52
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 32
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 8
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -1
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо -1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 5
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -110
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -123

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 6
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 34
- Гэрээний бүртгэл - 56
- Барьцааны гэрээний бүртгэл - 227
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -11

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 5

Архивын чиглэлээр:

- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар -102

Нийт 778 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

Цагдаагийн хэлтэс нь: Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1-ээр буюу 5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 1-ээр буюу 1.8 хувиар, нийт гомдол мэдээлэл 3-аар буюу 4.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд Сүмбэр сумын Засаг даргатай хамтран хөдөлгөөнт эргүүлд ажиллах явуулын постыг байгуулан 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд осол хэрэг ихээр гардаг газруудад байрлуулан хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 17 удаа ажилласнаас хулгайлах гэмт хэрэг 2, хүний амь нас эрсэдсэн 3, зам тээврийн ослын 9, бусад хэргийн газрын үзлэгт 3 удаа оролцсон. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 359 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги: Хоригдлуудыг нийгэмшүүлэх тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж сургалтын төлөвлөгөөний дагуу “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн хоригдлын авьяас, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор төрөл бүрийн дугуйлан сургалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна.

Тайлант сард төлбөрийн 234 гүйцэтгэх баримт бичгээс 67 гүйцэтгэх баримт бичгийн 642.019.8 мянган төгрөг, 15 хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 28.6 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь: 8 дугаар сарын 17-28-ны өдрүүдэд Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын 5 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 10 байгууллагын багшлах боловсон хүчний хангамж, сургалтын байр, танхимын цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл, хүүхдийн норм нормативыг хангасан байдал, багш, ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал болон бусад сургалтын үйл ажиллагаатай холбоотой бэлтгэл ажилд эрүүл ахуй халдвар хамгаалал, боловсролын хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналтыг хийж илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн боловсролын байгууллагын үйлчлэгч, тогооч, туслах багш нарт халдвар хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтанд 51 ажилтан, албан хаагч хамрагдсан.

Онцгой байдлын газар нь: Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ыг мөрдлөг болгон хяналт шалгалтыг зохион байгуулан илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2 байгууллагад олгож, 25.000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна. Аймгийн ой хээрийн түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж тайланг хүргүүлсэн. Үнэлгээгээр эрсдэлийн түвшин дунд үнэлэгдсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газраас ирсэн цаг агаарын шуурхай мэдээг хүлээн авч, багийн Засаг дарга нартай хамтран 186 малчин өрхөд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг мессежээр хүргүүлэн ажилласан.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Сургууль цэцэрлэгийн удирдлагуудад 2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл, өндөржүүлсэн бэлэн байдлын эрх зүйн асуудлыг танилцуулах сургалтыг

зохион байгууллаа. Сургалтанд сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нар оролцсон. Сургалтанд нийт 30 албан хаагч хамрагдсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн иргэдэд 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдөр зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 39 хүн хамрагдсан бөгөөд “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн тухай хууль”, “Архи түүний сөрөг нөлөө”, “Архи хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх нь”, “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвүүдийн хүрээнд мэдээлэл өгч, харилцан ярилцан, зөвлөгөө зөвлөмж өгч сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан иргэд хуулийн тухай мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж, гэр бүлийн харилцаандаа анхаарах зүйлс болон хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн талаар ойлголттой болсон юм.

2020 оны 8 дугаар сарын 6-ны өдөр “Стресс бухимдал түүнийг тайлах аргууд” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтаар стресс үүсгэх хүчин зүйлс, түүний сөрөг нөлөө, стресс тайлах эерэг аргуудын талаар мэдээлэл өгч, туршиж, харилцан ярилцаж, нээлттэй хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтад Цагдаагийн хэлтсийн 8 алба хаагч хамрагдсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монгол Улсын хошой мэргэн Т.Жаргалсайхан агсны нэрэмжит харваа, Боржигин шагайн харвааны уухай өв соёлын хүндэтгэлийн арга хэмжээ 2020 оны 8 дугаар сарын 9-нд зохион байгуулагдсан. Уг арга хэмжээнд Шивээговь, Сүмбэр, Баянтал, Дундговь аймгийн Баянжаргалан сумын 13 багийн 92 харваач оролцсон.

Эрүүл мэндийн талаар: Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2019 оны 8 сар	2020 оны 8 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	297	279
Гэрийн төрөлт	1	0
Амьд төрсөн хүүхэд	298	283
Амьгүй төрөлт	3	0
Нас баралт	36	46
Эмнэлгийн нас баралт	8	2
Хоног болоогүй нас баралт	3	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
Эмнэлгээс гарсан хүний тоо	3 223	2 855
Амбулаторийн үзлэг	63 368	60 120
Халдварт өвчин	119	64

Дэлхийн зөн Олон Улсын байгууллагатай хамтран Ковид 19 цар тахлын хорио цээрийн үед нийгмийн сэтгэл зүйд гарч буй өөрчлөлтболон цаашид олон нийтийн сэтгэл зүйн дэмжлэгийг олж тогтоох зорилгоор аймгийн 450 орчим иргэнээс судалгаа аваад байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр: “Аймгийн нийт нутгаар зуншлага сайн, бэлчээрийн ургац жигд байгаа ч 2019-2020 оны өвөл, хаварт отроор ирсэн малчид буцаагүй, өмнөх жилүүдэд бэлчээр нэлээд доройтсон, бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүн өөрчлөгдсөн зэргээс шалтгаалан бэлчээрийн даац, багтаамжид тохирсон мал өвөлжүүлэх, мал сүргээ дундаас дээш тарга хүч авахуулах, мал үржлийн технологит ажил үйлчилгээг чанартай гүйцэтгэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Өнгөрсөн өвөл, хаварт аймаг дундын Малх отрын бүсэд 4 аймгийн 110.0 мянган мал, отрын бүсээс гадна 60.8 мянган мал манай аймагт өвөлжиж, хаваржсан. Энэ нь 100 га бэлчээрт 138-150 хонин толгой буюу улсын дунджаас 1.76-2.0 дахин их байна. Иймд 2020 оны 7 дугаар сараас манай аймгийн нутагт өвөлжиж, хаваржаад, зусаж байгаа отрын малчдыг нүүлгэх, бэлчээр чөлөөлүүлэх ажлыг сумдын Засаг даргын Тамгын газар, Хөдөө аж ахуйн тасагтай хамтран зохион байгууллаа. Тухайлбал: 7 дугаар сарын 24-ний өдөр Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутагт отроор зусаж байгаа Дундговь аймгийн Гурвансайхан сумын 5, Говь-Угтаал сумын 1, Сайнцагаан сумын 1, Цагаандэлгэр сумын 1, нийт 8 айлд мэдэгдэх хуудас өгч, бэлчээр чөлөөлүүлэх ажлыг зохион байгууллаа. 2020 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар Дундговь аймгийн харьяат 40 өрхийн 57.1 мян.мал Сүмбэр, Баянтал сумын нутагт оторлож байна.

Хэнтий аймгийн Дархан сумтай хиллэх нутгийн зааг орчмын бэлчээр ашиглалттай холбоотой маргааныг зохицуулах, аймаг дундын Малх отрын бүсэд шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн цэг тогтоох зорилгоор “Малх” аймаг дундын отрын бүсийн мэргэжилтэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын бэлчээр, худаг ус хариуцсан мэргэжилтэн нарын хамтарсан ажлын хэсэг гарч, 2020 оны 07 дугаар сарын 23-нд Хэнтий аймгийн Дархан, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хилийн заагт хоорондоо 1-2 км зайтай шувууны суудал, үүр босгож, худаг гаргах цэгийг тогтоосон.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулахаар аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/228 дугаар захирамж, аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл хангуулах тухай” 01/01 дүгээр албан даалгаврыг гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Газар тариалан: 2020 оны ургацын урьдчилсан балансаар 10 га-д тэжээлийн ургамал, 17.9 га-д төмс, 21.7 га-д хүнсний ногоо тариалж, 20 тн тэжээлийн ургамал, 128.5 тн төмс, 151.1 тн хүнсний ногоо хураан авахаар байна. 2020 онд 1 га газарт уринш бэлтгэсэн.

Үйлдвэр, худалдаа үйлчилгээ: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох хүрээнд нийт 3.3 тэрбум төгрөгийн 21 төсөл хүлээн авч, цахим системд оруулан, “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 11.5.2 заалтын дагуу дүгнэж, 70 онооноос дээш үнэлгээтэй 14 төслийг дараагийн шатны шалгаруулалтад шилжүүлсэн.

2020 оны 08 дугаар сарын 20-ны байдлаар хүнсний чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүний татан авалт хэвийн бөгөөд хүнсний бүтээгдэхүүний бодит нөөцийг Сүмбэр сумын 13 цэг, Баянтал сумын 3 цэг, Шивээговь сумын 5 цэгээс тогтоов. Үүнд: махны нөөц 2 хоног, гурил 8 хоног, төрөл бүрийн будаа 6 хоног, төмс хүнсний ногооны нөөц 6 хоног, элсэн чихэр 6 хоног, бусад хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн 1-7 хоногийн нөөцтэй байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Биокомбинат био үйлдвэрээс бруцеллёзоос сэргийлэх Rev-1 вакцин 127.3 мян.тун, 19 дүгээр омгийн вакцин 3.06 мян.тунг хүлээж авсан. Бруцеллёзоос сэргийлэх вакцинжуулалтад нийт 130.3 мян.тол мал хамруулахаар төлөвлөсөн.

Мал, амьтныг шимэгчтэх өвчнөөс сэргийлэх мал угаалгын арга хэмжээг зохион байгуулж байна. Угаалганд нийт 428.0 мян.тол мал хамруулахаас 287 өрхийн 223.7 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 52 хувьтайтай байна.

“Малын эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дотоодын худалдааны хорио цээрт өвчнүүд болох адууны ям, адууны хачгийн халуун, адууны халдварт цус багасах, адууны нийлүүлгийн өвчний тандалт шинжилгээг 800 толгой адуунд хийж,

эдгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. 8 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар тус шинжилгээнд 66 өрхийн 800 цусны дээж цуглуулсан ба дээж цуглуулах ажлын 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2020 оны 8 дугаар сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай/ махны үнэ 800 төгрөгөөр, хонины мах /цул/ 800 төгрөгөөр, адууны мах /цул/ 500 төгрөгөөр, ямааны мах /цул/ 500 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-250 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	Ястай	11000	9500	+800
		Цул	12000	11000	-
2	Хонины мах	Ястай	9500	8000	
		Цул	10000	10000	+800
3	Адууны мах	Ястай	8500	7500	
		Цул	9000	9000	+500
4	Ямааны мах	Ястай	7000	6000	
		цул	9000	9000	+500
5	Тахианы мах	Гуя	10500	10000	
		мөч	9800	9000	
6	Лууван	монгол	2000	1200	-
		хятад			
7	төмс	монгол	1250	850	+250
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1200	
		хятад			-
9	чинжүү	монгол			-
		хятад	6500	5500	
10	Манжин	монгол	3800	3200	+50
		хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3000	2500	-
		Хятад	1500	1400	-
12	Улаан лооль	монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	монгол	8000	6500	-
14	Элсэн чихэр	монгол	2100	1600	-
15	Будаа	Цагаан задгай кг	2500	2200	+100
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	2500	2000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	3050	-
17	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-

18	Талх	Чойр талх	1200	750	-
19	Өндөг	ОХУ	400	330	-
		Монгол	400	300	-
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	+250
		Задгай 1-р зэрэг	1140	1100	+20
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
21	Ургамлын тос	Олейна	5500	4800	+50
		Алтан	3800	3600	-
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Япон улсын Засгийн газрын "ЖАЙКА" Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас говийн бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхээр ажлын хүрээнд урьдчилсан судалгаа хийж, аймгийн удирдлагуудтай уулзан аймаг, орон нутгийн хэмжээнд байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүн, цаашдын хөгжлийн төлөвлөлтийн талаар харилцан санал солилцлоо.

“Цэргийн алдар” цогцолборын ногоон байгууламжийн ус нөөцлөх сав, усалгааны шугам хоолой суурилуулах ажлыг “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-ын 39.3 сая төгрөгөөр “Жавхланта арвижих” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хүлээн авлаа.

2020 онд “Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-ын 8.0 сая төгрөгөөр “Аймгийн цөлжилтийн судалгааны ажил”-ыг “Ойн биологийн олон янз байдлыг төв”- тэй гэрээ байгуулан, гүйцэтгүүлж байна. Уг судалгааны ажлын явц 70 хувьтай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран орон нутагт хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг олгоод байна. Тус хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд аймгийн орчны бохирдлыг бууруулах зорилгоор аймгийн төвийн хогийн цэгийг өргөтгөх, хог хаягдлыг бууруулах тендер шалгаруулалтыг зарлаад байна. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Орон нутагт хаягдал хуванцар сав нягтруулах шахах, бутлагч төхөөрөмж суурилуулж хог хаягдлын зохистой менежментийг дэмжих” ажлын хүрээнд дахивар хаягдал нягтруулах төхөөрөмж нийлүүлэгдэж, суурилуулагдах ажил хийгдэхтэй холбоотойгоор орон нутагт хариуцан ажиллах иргэн, аж ахуй нэгж байгууллага, төслийн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын хүрээнд: 8 дугаар сард Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс 8 хугацааны мэдээ, нийт 248, климат агро дундаж мэдээ, Хөдөө, аж ахуйн тойм, 10 хоногийн тойм мэдээг 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Цаг агаарын нарийвчилсан урьдчилсан мэдээ өглөө 8 цаг 30 минутаас өмнө, нэг хоногийн урьдчилсан мэдээг 14 цагаас өмнө, 5 хоногийн урьдчилсан мэдээг 16 цагаас өмнө сервэрт байршуулж, <http://govisumber.tsag-agaar.gov.mn> цахим хуудсанд нарийвчилсан болон хоногийн тойм мэдээг 9 цаг 30 минутын дотор, 1-5 хоногийн урьчилсан мэдээг 14 цаг 30 минутын дотор, 7 хоногийн төлөв, 7 хоногийн тойм мэдээг даваа гариг бүр, сарын

урьдчилсан мэдээг 25-ны өдрийн дотор, сарын тойм мэдээг 5-ны өдрийн дотор тус тус веб сайтанд байршуулж ажиллалаа.

8 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар цаг уурын тойм мэдээ: 02, 07, 12, 13, 15, 16, 17, 18-ны өдрүүдэд бороо орж 35.2 мм тунадас унасан. Салхи ихэнхи хугацаанд 4-9 м/сек, зарим үед 10-12 м/сек хүрч салхилсан. Агаарын дундаж температур 17.6 градус дулаан, хамгийн хүйтэн нь 18-ны өдрийн шөнө 9.9 градус дулаан, хамгийн дулаан нь 06-ны өдөр 29,0 градус дулаан байсан.

8 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар хөдөө аж ахуйн цаг уурын тойм мэдээ: Бэлчээрийн нийт ургамлын ургалт сайн, бэлчээрийн ургамлын ажиглалтын төлөөлөх ургамал болох хялгана шинэ үе шатгүй, хөмүүлд үрийн боловсролтын үе шат хашаалсан ба хашаалаагүй талбайд явагдаж байна. Ургамлын дундаж өндөр 22 см байна. Бэлчээрийн ургамлын хөнөөлт хортон мэрэгчдийн ажиглалтаар авгалдай, бие гүйцсэн царцаа ажиглагдаагүй. Мал аж ахуйд зохиогдож байгаа ажил, малын бэлчээрлэлтэнд цаг агаарын байдал хэвийн ажил саатаагүй. Бог, бод малын тарга хүч сайн, худгийн болон тогтол усаар ундаалж байна.

Тайлант сард азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 2 удаагийн давтамжтайгаар сорьцыг 20 удаа, мөн шинжилгээг 10 удаа, 8 дугаар сарын 1-ний өдрөөс 17-ны өдрүүдэд дээжинд шинжилгээ хийсэн дундаж азотын давхар исэл (NO₂) 0.016 мкг/мг сарын хүлцэх агууламжийн хэмжээ 0.050 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.011 мкг/мг, сарын хүлцэх агууламжийн хэмжээ 0.050 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Аймгийн Засаг даргын захирамжаар олгогдсон газруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжид оруулан ажиллаж байна. Нийт 820 нэгж талбараас кадастрын мэдээллийн санд хүчинтэй 784 нэгж талбар байна. Үлдсэн 36 нэгж талбарын мэдээллийг нэг бүрчлэн оруулан ажиллаж байна. Мөн өмчлөлийн газраа бусдад худалдах, худалдан авах гэрээгээр шилжүүлсэн нийт 42 иргэний мэдээллийг кадастрын мэдээллийн сангийн цахим системд оруулсан.

Аймгийн хэмжээнд бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар үнэлэх хээрийн судалгааны ажлыг 8 дугаар сарын 6-10-ны өдрийн хооронд бэлчээр ашиглалтын 21 хэсгийн 43 цэгт хийсэн.

Газар эзэмших эрхтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагын 47 нэгж талбарын газар эзэмших гэрээг дүгнэсэн.

“Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын хүрээнд 2 удаагийн “Openforis, Collect earth” програмын онлайн сургалтанд хамрагдан, манай аймагт 5203 цэгт үнэлгээ хийхээр хууваариласнаас 3254 цэгт үнэлгээ хийсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд дамжин хэрэгжиж байгаа 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгын ажил 85 хувьтай, Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 80 хувьтай, Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 60 хувьтай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга угсралтын ажил 35 хувьтай, Сүмбэр сум 2-р багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 85 хувьтай, Чойрын хийдийн гол Дуганы барилга 90 хувьтай, аймгийн төвийн авто замын ажил 95 хувьтай, аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил 90 хувьтай тус тус хийгдэж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 65 хувьтай хийгдэж байгаа бөгөөд Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр

хийгдэж буй Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн их засварын ажил 80 хувьтай тус тус хийгдэж байна.

АОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй Найрамдал хотхоны өргөх станцын барилгын ажил 80 хувьтай, Сүмбэр сумын 2, 3 дугаар багт тоглоомын талбай байгуулах ажил 75 хувьтай, Гомбосүрэн ноёны нэрэмжит талбайн тохижилтын ажил 80 хувьтай тус тус хийгдэж байгаа бөгөөд Сүмбэр сумын 6 дугаар байрны фасад засварын ажил дуусч, ашиглалтад хүлээн авсан.

Худалдан авах ажиллагааны талаар: Улсын төсвийн хөрөнгөөр 9 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 7 ажлын тендер шалгаруулалтыг зарласнаас 5 бараа ажил үйлчилгээний ажил дуусч ашиглалтад хүлээн авсан, 1 ажил хийгдэж байгаа, 1 бараа ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээ хийгдэж байгаа, 1 тендер шалгаруулалтыг дахин зарлахаар бэлтгэж байна.

Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 16 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 7 бараа ажил үйлчилгээний ажил дуусч, 8 бараа ажил үйлчилгээ хийгдэж байгаа, 1 ажлын тендер шалгаруулалтыг зарласан байна.

Авто замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаар 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ажлыг 100 хувь гүйцэтгүүлсэн байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: Сумын төсвийн байгууллагууд хашаан доторх зэрлэг ургамлыг түүж, ойр орчмынхоо цэвэрлэгээг байнга хийж байна. Соёлын төв нь цахимаар соёлын биет бус өвийн талаар танилцуулан ажиллаж байна.

Бруцеллэз өвчнийг оношлох зорилгоор бог малын хээлтүүлэгч ялгасан 1 суурийн 19 өрхийн 155 хуц ухна, саалийн малнаас 11 өрхийн 245 толгой малыг тус тус хамруулж илдэсийг ялгаж мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.

“Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, нийтийн эзэмшлийн талбайн өнгө үзэмжийг сайжруулах” нийтийг хамарсан ажлын 6 дахь ээлж зохион байгуулагдаж, цэцэрлэгт хүрээлэнгийн өнгө үзэмжийг сайжруулж, цэвэр байлгах, 526 ширхэг таримал модны усалгаа арчилгааг хариуцан ажиллаж, гэрээний үүргээ хугацаанд нь амжилттай сайн гүйцэтгэлээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийтийг хамарсан ажилд хамрагдсан 3 иргэний цалин хөлсөнд 490.000 төгрөг, хөдөлмөр хамгааллын зардалд 19.600 төгрөг зарцуулсан байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Бүлгийн ногоо төсөл хэрэгжиж байна. Бүлгийн гишүүд хүнсний хэрэгцээндээ шинэ ургацын ногоо хэрэглэхийн зэрэгцээ, ургамлын арчилгаа усалгаа хийх талаар мэдлэг хуримтлуулж, ур чадвар эзэмшиж байна.

Шивээговь сум: “Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг дээшлүүлэх” сумын дэд хөтөлбөрийн хүрээнд суманд “Төрийн үйлчилгээний төв” байгуулах засвар, тохижилтын ажлыг “Оч хийц” ХХК-иар гүйцэтгүүлэхээр 9.8 сая төгрөгийн гэрээг байгуулан ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газарт Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 Олон улсын стандартыг нэвтэрүүлэх ажлыг зохион байгуулж төлөвлөгөөний дагуу байгууллагын “Алсын хараа”, “Эрхэм зорилго-Үнэ цэнэ”, “Чанарын бодлого” зэргийг шинэчлэн боловсруулсан.

Төрийн цахим үйлчилгээний 52 нэр төрлийн лавлагаа, тодорхойлолтыг 07 дугаар сард өссөн байдлаар 65 иргэнд олгосоноор иргэд аймаг орохгүйгээр сумаасаа цахим төрийн үйлчилгээг аваад байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээг 1 аж ахуй нэгж байгууллагатай байгуулан орон нутгийн орлогод 1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Аялал жуулчлалын бүс Хаялага нуурын эрэг, түр буудаллах цэгийн цэвэрлэгээг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж нийт 9.5 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.

Сум хөгжүүлэх сангаас 12 иргэнд 88 сая төгрөгийн зээлийг олгож үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Сүмбэр сум: 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Аяганы хонхорын ус хангамжийн эх үүсвэр болох ус түгээх цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Ус түгээх байрны орчин нөхцөл цэвэрлэгээ муу хийсэн, ус түгээгч эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаагүй, усны савыг ариутгал хийгээгүй зэрэг зөрчилтэй байсан бөгөөд илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай албан мэдэгдэл өгч гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Бэлчээрийн даац тодорхойлох, дээж авах ажлыг 8 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд хөдөөгийн 3 багуудад зохион байгууллаа. Нийт 26 цэгээс фотомониторингийн аргаар нэг цэгээс 3 удаа дээж авч ажиллалаа.

6 багийн 332 малчин, мал бүхий иргэн, 1 аж ахуйн нэгжийн 90537 кг хонины ноосны падаан, 8 малчин өрхийн 202 кг тэмээний ноосны падааныг тулгалт хийн программд шивж оруулсан.

Сумын мал эмнэлгийн тасаг “Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 800 адуунаас цусны дээж авлаа. Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын эмч нартай хамтран 1500 малд угаалга, ариутгал хийлээ.

Аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран мод, бутны тооллогыг явуулж байна. 2020 оны 8 дугаар сарын 14-ний байдлаар 17 өрх, 3 аж ахуйн нэгжийн мод, бутыг тоолж бүртгэлжүүлсэн. 2020 онд шинээр модны урамшуулалд хамрагдах 4 иргэн, 3 аж ахуйн нэгж байна.

2020 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Сүмбэр сумын 5 дугаар багийн төв, Уулзварын гол, Дунд уул, Дарь эх, Цоорхойн рашааны маршрутаар цэвэрлэгээ зохион байгуулж нийт 7 тонн хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүллээ.

Орон нутагт бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэж байгаа “Борхойн зам” ХХК нь түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээ байгуулж, Орбитын хогийн цэгийн урд карьераас шар шороо олборлож байсан. Тухайн компаний гэрээний хугацаа дуусч, олборлолт явуулж байсан талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэж буй үйл явцтай танилцлаа. Стандартын дагуу Техникийн нөхөн сэргээлт 80 хувьтай хийгдэж байна

Аймгийн Замын цагдаагийн тасагтай хамтран тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналтанд гарч, дайран өнгөрч байгаа тээврийн хэрэгслэлд үзлэг шалгалт хийж, гарын авлага тарааж, заавар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн сумын төвийн 108 өрхөд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгсөн байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР